

**“Мөнгөн тэмдэгтийн соёлтой хэрэглээ” аяны хүрээнд
сэтгүүлчдийн дунд зохион байгуулах уралдааны удирдамж**

Уралдааны зорилго: Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох “төгрөг”-ийн насжилтыг уртасгаж, түүнд зарцуулагдаж буй өртөг зардлыг бууруулах зүй ёсны шаардлага байгаа бөгөөд энэ нь иргэдийн төгрөгтэй харьцах соёлоос ихээхэн хамаарч байна. Төгрөг нь Монгол Улсын нэрийн хуудас тул мөнгөн дэвсгэртэд цэвэр нямбай хандах, мөн зөвхөн төлбөр тооцоонд зориулагдсан төлбөрийн баталгаат хэрэгсэл болохыг нь хувьд зориулалтын бусаар ашиглахгүй байхыг олон нийтэд таниулан ойлгуулахад энэхүү уралдааны ач холбогдол оршино.

Уралдаанд хамрагдах хүрээ: Хэвлэл мэдээллийн бүхий л хэрэгсэл

Уралдаанд тавигдах шаардлага: Уралдааны зорилгод нийцсэн агуулга бүхий бүтээлийг нийгмийн ухамсарт тусахуйц байдлаар хүргэсэн байх, үүнд бичлэгийн төрөл хамаарахгүй ба оролцогчид шалгаруулалтаас өмнө бүтээлээ олон нийтийн хүртээлд хүргэсэн байх.

Шагналын сан:	1 дүгээр байр	500 000 төгрөг
	2 дугаар байр	400 000 төгрөг
	3 дугаар байр	300 000 төгрөг

Бүтээл хүлээн авах хугацаа: 2017 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 18:00 цаг хүртэл Монголбанкинд хүлээн авна.

Шалгаруулалт: 2017 оны 6 дугаар сарын 28-ны өдөр

**МОНГОЛБАНКНЫ
МӨНГӨН ТЭМДЭГТИЙН ГАЗАР**